



СУРГУУЛИУДАД ҮЗҮҮЛЖ БУЙ MEDICAID/FAMIS ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ НИЙТЛЭГ АСУУЛТУУД:

Хөгжлийн бэрхшээлтэй Иргэдийн боловсролын тухай хууль (IDEA)-ийн дагуу зарим ганцаарчилсан сургалтын үйлчилгээ (IEP)-г Medicaid даатгалаас хариуцахаар заасан ба тиймээс Арлингтоны ЕБС зохих үйлчилгээний нэхэмжлэхийг Виржиниа мужийн Эрүүл Мэндийн тусламжийн (DMAS) газар илгээж байхаар болсон юм. Эдгээр үйлчилгээнүүдэд биеийн засал, мэргэжлийн согог засал, яриа/хэлний заслын үйлчилгээ, мэргэшсэн сувилагчийн болон асрагчийн үйлчилгээ, тусгай зориулалтын тээврийн үйлчилгээ болон тодорхой нэр төрлийн шалгалт үнэлгээ зэрэг багтдаг болно. Medicaid-н газарт үйлчилгээний нэхэмжлэхийг илгээхийн тул Арлингтоны ЕБС нь эцэг эхийн зөвшөөрлийг авах ёстой юм.

Сургуулиудад үзүүлж буй Medicaid хөтөлбөрт хамрагдах үйлчилгээтэй холбоотой ирдэг түгээмэл асуулт хариултуудыг дор жагсаав.

1. Medicaid/FAMIS -т нэхэмжлэх илгээхийн тулд яагаад эцэг эхийн зөвшөөрөл авдаг вэ?

Гэр бүлийн Боловсролын эрх, нууцлалын тухай Акт (FERPA)-н дагуу Арлингтоны ЕБС хөгжлийн бэрхшээл бүхий сурагчийн мэдээллийг бусдад дамжуулахаас өмнө эцэг эхийн зөвшөөрөл авсан байх ёстойг заасан. Иймээс Medicaid хөтөлбөрт төлбөрийн нэхэмжлэх явуулах нь энэ ангилалд багтаж байгаатай холбоотой.

2. Манай хүүхдийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөрт тусгасан үйлчилгээний нэхэмжлэхийг Medicaid/FAMIS явуулах бүрт эцэг эхийн зөвшөөрлийг авч байх уу?

Эцэг эхийн зөвшөөрөл зөвхөн нэг удаа шаардлагатай. Учир нь тухайн зөвшөөрөл танай хүүхэд Арлингтоны ЕБС-д байх хугацаанд буюу ганцаарчилсан сургалтын хөтөлбөрт заасан төлбөртэй үйлчилгээ авах шаардлагагүй болох хүртэл, эсвэл эцэг эх нь тухайн зөвшөөрлийг татаж авах хүртэл хүчинтэй байх юм.

3. Манай хүүхэд Medicaid авах эрхгүй ч би энэ зөвшөөрлийг өгөх ёстой юу?

Тийм. Танай хүүхэд Medicaid хөтөлбөр авах эрх үүссэн нөхцөлд зөвшөөрөл сурагчийн хувийн хэрэгт хадгалагдаж байх ёстой.

4. Би зөвшөөрөл өгсний дараа зөвшөөрлийг цуцалж болох уу?

Эцэг эхийн зөвшөөрөл сайн дурын шинжтэй ба эцэг эх хүссэн үедээ цуцлах боломжтой. Хэрэв та зөвшөөрөл өгсөн ч хожим зөвшөөрлөө цуцалсан нөхцөлд энэ нь өнгөрсөн хугацаанд ухарч үйлчлэхгүй ба зөвшөөрөл хүчинтэй байх үед үзүүлсэн үйлчилгээний нэхэмжлэхийг Medicaid албанд илгээх болно. Хэрэв та зөвшөөрлөө цуцлахыг хүсвэл (703)228-6065 тоот утсаар Medicaid зохицуулагчтэй холбогдоно уу.

5. Хэрэв би зөвшөөрөл өгөхгүй бол яах вэ?

Танай хүүхдэд үзүүлж буй боловсролын хөтөлбөр нь ганцаарчилсан сургалтын хөтөлбөрт тодорхойлсон танай хүүхдийн сурлагын хэрэгцээнд суурилсан байдаг. Таны зөвшөөрөл өгөх эсэх шийдвэр нь сурагчид үзүүлэх сургалт үйлчилгээнд ямар нэгэн замаар огт нөлөөлөхгүй. Гэвч зөвшөөрөл өгөхөөс татгалзах нь тухайн сургуулийн дүүрэг хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжих боломжид нөлөөлж болно.

6. Хэрэв манай хүүхэд Medicaid/FAMIS даатгалаас гарвал яах вэ?

Арлингтоны ЕБС нь зөвхөн Medicaid/FAMIS даатгал авах эрх бүхий сурагчдын нэхэмжлэхийг илгээдэг. Medicaid/FAMIS даатгал зогссоноор тухайн сурагчид сургуулиас үзүүлж буй үйлчилгээнд нөлөөлөхгүй.

7. Medicaid/FAMIS-т нэхэмжлэх илгээснээр миний мэдээлэл алдагдах эрсдэлтэй юү?

Арлингтоны ЕБС-аас Medicaid-д нэхэмжлэх илгээх зарчим эмнэлэг эмч нарын журамтай адил байна. Арлингтоны ЕБС нь таны эрүүл мэндийн холбоотой мэдээллийг чандлан нүүцлэхтэй холбоотой Холбооны болон мужийн хуулийг нарийн мөрдөж ажилладаг. Танай хүүхдийн мэдээлэлд зөвхөн тухайн процест шууд оролцож буй хүмүүс нэвтрэх эрхтэй байдаг.

8. Миний хувийн даатгалд ямар нэг нөлөө үзүүлэх үү?

Үгүй. Арлингтоны ЕБС ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд үзүүлсэн үйлчилгээний нэхэмжлэхийг хувийн даатгалд илгээдэггүй. Энэ зөвшөөрөлд гарын үсэг зурснаар таны юм уу танай гэр бүлийн хувийн даатгалаас юм уу Medicaid/FAMIS -с авдаг бусад төрлийн даатгалын үйлчилгээнд нөлөөлөхгүй.

9. Сургуулиас нэхэмжлэл илгээх нь бидний хувийн даатгалаас ногдуулсан эмчилгээ үйлчилгээнд хамрагдахыг зөвшөөрсөн нийт тоонд нөлөөлөх үү?

Үгүй. Арлингтоны ЕБС үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэх нь таны болон танай гэр бүлийн хувийн даатгалаас зөвшөөрөх үйлчилгээний тоонд нөлөөлөхгүй. Гадны эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн Medicaid/FAMIS-ийн эмчилгээ

үйлчилгээг сургуулийн зүгээс үзүүлсэн үйлчилгээнээс тусад нь санхүүжүүлэхээр зохицуулдаг.

10. Яагаад Medicaid-ийн нэхэмжлэх сургуулийн системээр дамжих ёстой вэ?

Нэхэмжлэхийг ийнхүү шууд илгээснээр сурагчдад үзүүлж буй зардлыг нөхөхөд дөхөм болдог.

Хэрэв танд ямар нэгэн асуулт байгаа бол Medicaid-ийн зохицуулагч Catina Claytor-тай холбогдоно уу

1426 N. Quincy Street
Arlington, VA 22207
(703) 228-6065
catina.claytor@apsva.us